

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +21
Шөнө +13

САЙХАН МЭДЭЭ

ОРОН СУУЦТАЙ БОЛОХ БОЛОМЖ БУЮУ ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ҮРГЭЛЖЛЭХ НЬ

II нүүрт

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

СУРГАЛТЫН ТӨЛБӨР ӨРХИЙН ТӨСВИЙГ ХООСОЛЖ БАЙНА

IV-V нүүрт

Дугаарын **60** мөр
Монгол буурай орон мөн үү

Б.ДАВАА

Бразилийн нийслэл Рио де Жанейро хотноо хүн төрөлхтний бэлгэдэл болсон Олимпын наадам эхлээд 10 гаруй хонож буй. Наадмын сэтгэл догдуулсан торгон агшин, олимпын анхны мөнгөн медальтай зэрэгцээд Монгол Улсын өрийн хэмжээ хэдэн их наядад хүрч хүн бүр бүсээ чангалах болсныг албаныхан санууллаа. Ам.доллар, рубль, юань гэх мэт валютын төгрөгтэй харьцах ханш өсч, үүнийг дагаад өргөн хэрэглээний барааны үнэ ч нэмэгдэж эхлэв. Бүр болоогүй олимпын дэвжээнд зодоглоод луйвардуулж ялагдсан нэгнийгээ хүртэл ядуу буурай оронд төрсний гай хэмээсэн постууд цахим сүлжээгээр тэнүүчлэх болов. Шуудхан хэлэхэд, аль эртнээс л ядуу буурай орныхон гэж ирээд л өөрсдийгөө цоллож, мөнхийн тийм хэмжээнд үнэлэгдэх юм шиг санаж явжээ, бид. Монгол Улс үнэхээр буурай орон мөн үү.

Үргэлжлэл нь III нүүрт

ЭСРЭГ ТЭСРЭГ БАЙР СУУРЬ



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

ХЭН НЬ “ЧОНЫН АРЬС” НӨМӨРСӨН БАЙСНЫГ ЦАГ ХУГАЦАА ХАРУУЛНА

Ж.ОТГОН

Сангийн сайд Б.Чойжилсүрэн өнгөрсөн долоо хоногт Монгол Улс ирэх сард төрийн албан хаагчдын цалинг тавихад маш хүнд байна, “Сайн

хөтөлбөр”-үүдийг бүгдийг нь зогсооно, валютын нөөц дууссан гэдгийг олон нийтэд зарласан. Энэхүү мэдэгдлийн дараа тэртэй тэргүй хүндэрчихсэн эдийн засгийг бүр дэвэргэлээ хэмээн шүүмжлэх хүн олон гарч ирэв. Тэгвэл

уг асуудлын хүрээнд уржигдар Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нар дахин хамтран мэдээлэл хийсэн нь олон түмнийг, тэр дундаа төрийн албан хаагчдыг бухимдуулаад авлаа. Гэтэл УИХ дахь

АН-ын булгийн дарга С.Эрдэнэ, УИХ-ын гишүүн З.Нарантуяа нар Төрийн ордонд өчигдөр хэвлэлийн бага хурал зарлан, ерөнхий сайд болон Сангийн сайдын хийсэн мэдээллийг үгүйсгэсэн юм.

Үргэлжлэл нь III нүүрт

EIKO Амьдрал амтай

DUAL TV

Нэг телевизортэй гээд дуртай нэвтрүүлгээсээ хоцрох хэрэггүй

- DUAL VIEW
- LIVE REC
- 3D GLASS
- SMART android os

- ✓ Нэг зэрэг 2 суваг ҮЗЭХ
- ✓ 3D КОНТЕНТ ҮЗЭХ
- ✓ Ухаалаг СИСТЕМ
- ✓ Шууд бичлэг ХИЙХ

ГЭР БҮЛИЙН ЗУРАГТНЫ ШИНЭ ХУВЬСАЛ

Нэг зурагтаар нэгэн зэрэг 2 хөтөлбөр үзэх шинэ технологи бүхий Eiko dual зурагт нь тусгай шилний тусламжтайгаар дэлгэцээ хуваалгүйгээр гэр бүлийн 2 гишүүн зэрэгцэж суугаад хүссэн кино, нэвтрүүлгээ үзэх боломжийг танилцуулж байна. Мөн ухаалаг утаснаасаа зурагтаа удирдах, гар утсан дээр зураг, видеог зурагтаараа үзэх боломжтойгоос гадна дуртай нэвтрүүлгээ зурагтан дээрээ бичиж аван дахин үзэх боломжтой. Шинэ технологи, ухаалаг хэрэглээ, хэмнэлтэй сонголт

7575-3535 | www.pc-mall.mn | PCmallOfficial


ОНЦЛОХ МЭДЭЭ

“Эрдэнэт” үйлдвэрийн архив

ОНЦ ДҮН АВЛАА



Монгол Улсын Хууль зүйн сайдын тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, нийслэлийн болон төрөлжсөн төрийн архивын үйл ажиллагаанд явуулсан улсын үзлэгт “Эрдэнэт” үйлдвэр ХХК-ий Төрөлжсөн архив “Маш сайн” гэсэн үнэлгээг авчээ. Улсын үзлэгт нийт 34 аймаг, нийслэл, төрөлжсөн төрийн архив хамрагдаж, хоёр сарын турш ажил үйлсээрээ уралдсан байна. Монгол Улсын Архивын тухай хууль, Төрийн архивын ажлын үндсэн заавар болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах, төрийн архивуудын үйл ажиллагааны түвшинг тогтоож дүгнэлт хийх, цаашид авах арга хэмжээний зорилт чиглэлийг тодорхойлж, шийдвэрлүүлэхэд улсын үзлэгийн зорилго оршижээ. “Эрдэнэт” үйлдвэрийн төрөлжсөн архив нь компанийн түүхэн ач холбогдолтой, үнэт баримт бүхий 64 хөмрөгийн 41196 цаасан суурьтай баримт, 2544 тусгай төрлийн баримтууд хадгалж цех, нэгжүүдийн дунд, архивын сан хөмрөгөө баяжуулах “Түүхээ бичье” уралдаан, компанийн үүсэл, хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан алдартан, гавьяатуудын хувийн хөмрөг үүсгэх ажил, компанийн түүхэн баримтаас ажилтнууд, иргэдэд сурталчлах “Архивын нээлттэй өдөрлөг” зэргийг амжилттай зохион байгуулдаг байна. Тус архив жилд дунджаар 3800 лавлагаа, хуулбар гаргаж ажилласныг үзлэг шалгалтын ажлын хэсэг сайшаан тэмдэглэжээ. Мөн цаашид орчин үеийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангагдсан архивын зориулалтын байртай болох асуудлыг шийдвэрлэх шаардлагатайг улсын үзлэгийн комисс онцолсон аж.



ХААН банк					Хугалгаа хөгжлийн банк						
	Авах	Зарах	Авах	Зарах		Авах	Зарах	Авах	Зарах		
АМ.ДОЛЛАР	2230.00	2248.00	ФУНТ	2837.00	2948.00	АМ.ДОЛЛАР	2237.00	2253.00	ФУНТ	2869.00	2986.00
ЕВРО	2478.00	2557.00	РУБЛЬ	32.70	37.00	ЕВРО	2492.00	2594.00	РУБЛЬ	33.92	37.38
ИЕН	22.01	22.76	ЮАНЬ	335.00	342.40	ИЕН	22.00	23.00	ЮАНЬ	335.30	342.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар



САЙХАН МЭДЭЭ



Улаанбаатарт Эдвард Мюнхийн үзэсгэлэн нээгдэнэ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд Норвеги улсад суугаа Өргөмжит Консул Шэйтл Крэйныг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон байна. Норвеги Улсад суугаа өргөмжит консул Шэйтл Крэйн “2018 онд тохиох Монгол, Норвегийн хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Норвегийн алдарт зураач Эдвард Мюнхийн уран зургийн үзэсгэлэнг Улаанбаатар хотод гаргахаар төлөвлөж байгаа юм. Энэ тал дээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг хүсч байна. Уг үзэсгэлэнг гаргах талаар Монгол Улсын Гадаад хэргийн яам, Боловсролын яамтай хамтран ажиллаж байна” гэв. Мөн тэрбээр Осло хотод динозаврын үзэсгэлэнг гаргах хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Харин нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд “Юуны өмнө Норвегийн алдарт зураач Эдвард Мюнхийн уран зургийн үзэсгэлэнг Улаанбаатар хотод гаргахад бэлэн байгаагаа илэрхийлэе. Ажлын хэсэг байгуулж, бүх талаар дэмжин ажиллах болно. Мөн ойн хүрээнд 2018 онд Осло хотод Улаанбаатарын соёлын өдрүүдийг зохион байгуулж, түүнчлэн хот төлөвлөлт, зам тээвэр, логистик салбарын үйл ажиллагааны талаар туршлага солилцох, мэргэжилтэн бэлтгэх, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлтэй байна” хэмээжээ.



ОРОН СУУЦТАЙ БОЛОХ БОЛОМЖ

...Ерөнхий сайд нэгэн сайхан мэдээ дуулгасан нь, “Засгийн газар орон сууцны найман хувийн зээлийг үргэлжүүлнэ” гэдгээ мэдэгдсэн явдал. Одоо харин урьдчилгааг хөнгөрүүлж, орон сууцныхаа үнийг жаахан тогтворжуулчихвал олон хүн мөрөөдлөө биелүүлэх боломжтой болно доо...

Э.МӨНХ

Залуу халуун насандаа гэр бүлтэй болж, өөрийн гэсэн орон сууцтай, унах унаагай бусдаас дутахгүй амьдрах чин хүсэлтэй хүн олон бий. Гэвч энэ мөрөөдлийг биелүүлэхэд ихээхэн бэрхшээл туулна. Ажлын туршлагагүйгээсээ болоод авдаг хэд нь бага нөхдүүд бол бүр ч хэцүү. Орон сууцтай болох гэдэг мөрөөдөл л гэсэн үг шүү дээ. Гэтэл



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

Монгол Улсын Засгийн газраас мөргөйжийн зээл гэгчийг гаргаж, цалин багатай залуустаа байртай болох боломжийг бий болгосон. Цаашлаад найман хувийн ипотекийн зээл таван хувь хүртлээ буурч, урьдчилгаа 30 хувиас 10 хүртэл буурч болох тухай яригдаж, эхний ээлжийнхэн мөрөөдлөө биелүүлэхэд эдүгээ халуун усаа хананаасаа аваад, паалантай жорлонд бие засаад жаргаж байна. Дахиад олон

хүн урьдчилгаагаа цуглуулж, байртай болох мөрөөдлөө биелүүлэх гэж байтал банкууд материал хүлээн авахаа больж, Засгийн газар орон сууцны зээл болох найман хувийн зээлийг тодорхой шалтгаануудын улмаас түр зогсоох шийдвэрийг гаргаснаар мөрөөдөл талаар болсон. Иргэдийг орон сууцжуулах зорилгоор гаргасан найман хувийн хүүтэй орон сууцны зээлийг Засгийн газар арилжааны банкуудаар

дамжуулан гаргасан. Монголбанкны мэдээгээр өнгөрсөн зургадугаар сарын байдлаар 8464 иргэний 520.7 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтийг хүлээн авч, 2495 иргэний таван хувийн хүүтэй 118 тэрбум төгрөгийн, 4776 иргэний найман хувийн хүүтэй 321.4 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгохоор шийдвэрлэсэн байна. Гэвч банкууд энэ зээлийг олгохгүй болсноо мэдэгдэж, мөнгөний

эх үүсвэр, санхүүжилт байхгүй гэсэн шалтгаанаар хэзээ үргэлжлэх нь тодорхойгүй, таг зогсох нь тэр. Харин Ерөнхий сайд нэгэн сайхан мэдээ дуулгасан нь, “Засгийн газар орон сууцны найман хувийн зээлийг үргэлжүүлнэ” гэдгээ мэдэгдсэн явдал. Одоо харин урьдчилгааг хөнгөрүүлж, орон сууцныхаа үнийг жаахан тогтворжуулчихвал олон хүн мөрөөдлөө биелүүлэх боломжтой болно доо.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.



Монгол, Хятадын сэтгүүлчид чуулна

“Монгол Хятадын хэвлэл мэдээллийн VII форум”-ыг ирэх амралтын өдрүүдэд буюу энэ сарын 19-21-ний хооронд Хэнтий аймгийн Чингис хаан хотноо зохион байгуулахаар болсон талаар Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс мэдээллээ. Монгол Улс, БНХАУ-ын хооронд байгуулагдсан стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрийн хүрээнд Монгол Хятадын хэвлэл мэдээллийн форумыг хоёр улс жил бүр ээлжлэн зохион байгуулахаар болсон байдаг. Жил бүр талууд өөр өөр сэдвийг онцлон хэлэлцэж, тулгамдсан асуудлаа ажил хэрэг болгохоор хамтран ажилладаг хэмээсэн.

Тухайлбал, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа аймагт болсон өнгөрсөн жилийн хоёр улсын сэтгүүлчдийн форумаар Ази Европыг холбосон эдийн засгийн коридорыг хэрхэн байгуулах, ямар боломж буйг хоорондоо хэлэлцэж, энэ сэдэвтэй холбоотой мэдээ мэдээллийг хоёр улсын хэвлэлийн байгууллагууд, сэтгүүлчид тууштай хөндөн бичсэн. Энэ нь саяхнаас

Ази Европыг холбосон авто замын тээвэр хөдөлж эхлэхэд сэтгүүлчид чухал нэмэр оруулсан гэж МСНЭ-ийн ерөнхийлөгч Б.Галаарид ярьсан юм. Харин энэ удаад Их эзэн Чингис хааны өлгий нутагт болох долоо дахь удаагийн форумаар Монгол, Хятадын харилцаа, хоёр улсын хэвлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааны асуудлыг хөндөх ажээ. Мөн “Хятад улсыг танин мэдэх Монгол Улс дахь аян” нэртэй Өвөрмонголын IV соёлын өдрүүдийг Улаанбаатар хотноо энэ сарын 18-30-ны өдрүүдэд зохион байгуулахаар болжээ. Соёлын өдрүүдэд монголчууд Хятад, Өвөрмонголын урлаг соёлын тоглолтыг үзэж, Хөх хотын ногоон байгууламж, эртний түүхийг өгүүлсэн уран зургийн үзэсгэлэнгээр аялах боломжтой гэнэ. Үүнээс гадна хэдхэн жилийн өмнө “Авьяаслаг Хятадууд” шоу-нд МУГЖ, дуучин С.Жавхлангийн дуулсан “Алсад суугаа ээж” дууг дуулж олны хайрыг хүртсэн дуучин хүү н.Уудам болоод түүний Таван тансаг Хөлөнбуйрын хүүхдийн найрал дууны чуулгын концерт болох юм байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд цэцэрлэгтэй болно

Дархан-Уул аймагт цэцэрлэгийн насны 7000 хүүхэд байдгаас 56 нь хөгжлийн бэрхшээлтэй ажээ. Эдгээр хүүхдүүдэд тусгай арчилгаа, сувилгаа шаарддаг тул эцэг, эхийн аль нэг нь ажлаасаа гардаг байна. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх тусгай боловсрол олгодоггүй бөгөөд тэднийг цэцэрлэгт хамруулдаггүй гэнэ. Тиймээс Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг /ТИКА/ Дархан-Уул аймгийн долдугаар

цэцэрлэгийн дэргэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан анги, сэргээн заслын төв байгуулахаар болсон байна. ТИКА барилга угсралтад 35 мянга орчим ам.долларын хөрөнгө оруулалт хийж, хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө дуусгахаар төлөвлөжээ. Шинэ анги, сэргээн заслын төв байгуулснаар улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгодог улсын хэмжээний хоёр дахь цэцэрлэг бий болох гэж байна.



С.Батболд модон жорлонд “хайртай” юм байна

Х.НОРЖИН

МАН-ын нэр хүнд өдрөөс өдөрт унаж байгаа энэ эгзэгтэй үед нийслэлийн Засаг дарга С.Батболдын модон жорлонд хайр зарласан явдал дайран дээр давс нэмсэнтэй адил болов. Учир нь тэрбээр цэвэрлэх байгууламжид шинэ технологи нэвтрүүлэхээр ажиллаж буй Монгол Улсын зөвлөх инженер З.Занданпүрэвт хэвлэл, мэдээллийн хэрэгслээр энэхүү технологийнхоо талаар ярилцлага өгч болохгүй гэх үүргийг

өгчээ. Хүнлэг ардчилсан нийгэмд өөрийн хийж буй ажил үйлсийн талаар ярилцлага өгч, байр суурь, үзэл бодлоо илэрхийлж болохоо больж гэхээр бид чинь эргээд социалист нийгэм рүүгээ шилжих гээд байгаа хэрэг үү. Эсвэл Засаг дарга маань нийслэлийн гэр хорооллын иргэдийг модон жорлонтой нь байлгах аваас орон нутаг болоод Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгнө хэмээн тэнэгтэж суумгүй байлтай. Улс төрөө гэж. Жорлонгоор хүртэл улс төр хийчих юм аа.

Төв талбайн нэр хуучин хэвэндээ орлоо



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

Э.ТУУЛ

Монгол Улсын төв цэг буюу Төрийн ордны өмнөх талбайн нэрийг мөн ч их оролдож байна даа. Угтаа бол нийслэлийн төв талбайг Сүхбаатарын талбай гэж нэрлэсээр хэдэн арван жилийг элээсэн түүхтэй. Гэвч 2014 онд НИТХ гэнэт Чингисийн талбай гэж нэрлэх шийдвэр гаргасан нь иргэдийн эсэргүүцэлтэй тулгарсан. Жанжны үр удам ч үүнийг эсэргүүцэж буйгаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, эцэстээ энэ асуудал шүүхийн шатанд очсон. Иргэд ч хэсэгтээ эсэргүүцэж байгаад тэгсхийгээд Чингисийн талбай гээд нэрлээд сурчихсан. Гэтэл Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхээс НИТХ-ын Сүхбаатарын талбайг Чингисийн хэмээн нэрлэх шийдвэрийг хууль зөрчсөн гэсэн шийдвэрийг өнгөрсөн онд гаргаж байв. Шийдвэр гарснаас хойш 14

хоногийн дотор хариуцагч тал буюу НИТХ дээд шатны шүүхэд давж заалдах эсэхээ шийдэх ёстой, энэ асуудал дээр шүүхдэлцэх шаардлагагүй гэх мэтчилэн хуульчид тайлбарлаж байсан цаг саяхан. Тэгвэл 2016 оны сонгуулиар МАН үнэмлэхүй олонхи болж, өөрсдөө засгийн эрхийг бүрэн атгах боломжтой болсон. Яг энэ үед Сүхбаатарын талбайн нэрийн асуудлаар Захиргааны хэргийн шүүх эцсийн шийдвэрээ гаргажээ. Шүүхийн шийдвэрээр талбайн нэр хэвээрээ буюу Сүхбаатарын талбай хэмээх хуучин нэрээрээ нэрлэгдэхээр болсон байна. Энэхүү мэдээг сонссон жанжны үр удам “Шүүх хуралд ажилласан хуульч өмгөөлөгч нартаа гэр бүлийн зүгээс гүн талархлаа илэрхийлэе” хэмээн фэйс хуудсаараа дамжуулан талархал илэрхийлжээ. Ямартай ч нэг нам гарахаар л гудамж талбайн нэр өөрчилдөг ажил уламжлал болох бололтой дог шүү.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

Монгол буурай орон мөн үү

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Дэлхийн банк НҮБ-ын Үндэсний нийт орлого, хувь хүний хөгжлөөр үнэлэх статистик судалгаагаар манай улс буурай бус хөгжиж буй улсын жагсаалтад багтдаг аж. Ядуу буурай гэх тодотгол бүхий дээлээ тэртээ 1991 оны сүүлээр тайлж шиджээ. Одоогийн байдлаар дунд орлоготой хөгжиж буй улсын тоонд Монгол багтаж байна. Тодруулбал, 1991 оноос хойш 20 орчим жил бага орлоготой, хөгжиж буй гэсэн (LIDC-Low income developing country) статустай байв. Харин 2010 оноос эдийн засгийн үзүүлэлтүүдийн хувьд дунд орлоготой улсын нөхцлүүдийг хангаж эхэлсэн бөгөөд үүндээ тааруулан төсөв, санхүү болоод хууль, эрх зүйн орчноо өөрчлөх шаардлагатай болж, Засгийн газрын дотоодын үнэт цаасны буюу бондын зах зээлийг хөгжүүлсэн нь өөрчлөлтийн чухал хэсэг болжээ. Харин бидний яриад байгаа шиг “Least developed countries” буюу нэн ядуу буурай улсын жагсаалтад одоогийн байдлаар 48 улс багтдаг юм байна. Үүний ихэнхэд Африкийн орнууд багтдаг бөгөөд 34 нь хар тивийнх, ес нь Азийнх, Номхон далайн арлуудын дөрвөн улс, Латин Америкийн нэг орон нэрлэгджээ.

Хөгжиж буй орны жагсаалтыг бага орлоготой хөгжиж буй орон, дунд орлоготой хөгжиж буй орон хэмээн ялгасан байх бөгөөд Афганистан, Буркино Фасо, Бурунди тэргүүтэй 30 улс бага орлоготой хөгжиж буй орон гэсэн статустай. Манай улсын хувьд Үндэсний нийт орлого нь 3830 ам.доллар, хүний хөгжлийн индекс 90 гэсэн үзүүлэлтэйгээр дунд орлоготой хөгжиж буй орны жагсаалтад Украин, Узбекистан, Филиппин, Мьянмар гэх улсуудын хамт бичигдсэн байх жишээтэй. Нөгөө талаар ээлжих зэрэглэлийг томоохон агентлагууд хэрхэн үнэлснийг сонирхож үзье. Санхүүгийн зах зээл хөгжиж, хөрөнгө оруулалтын олон боломж бий болсноор ээлжих зэрэглэлийг тогтоох нь энэ салбарын чухал асуудал болсон. Зээлжих зэрэглэл сайтай улс, компанид хөрөнгө оруулалт их хийгдэх, зээлийн хүү бага тогтох давуу тал болдог бол бага зэрэглэлтэй улсын хувьд зээлийн хүү өндөр тогтож тухайн оронд хөрөнгө оруулагчид итгэх итгэл бага байдаг аж. Одоогоор дэлхийд Standard and Poor's, Fitch, Moodys гэсэн зэрэглэл тогтоогч гурван байгууллага нийт зах зээлийн 95 хувийг хамарч үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Тэгвэл эдгээр гурван байгууллага Монголын ээлжих зэрэглэлийг хэрхэн үнэлснийг сонирхож үзвэл, S&P агентлаг “В+” зэрэглэлээс бууруулж “В” гэж үнэлсэн бол Moody's B2, Fitch “В” гэж тус тус үнэлжээ. Ийнхүү ээлжих зэрэглэлийг бууруулан үнэлэх болсон гол шалтгааныг манай улсын эдийн засаг хөрөнгө оруулалтын бус, эрсдэлтэй, зах зээл саваалгаатай байгаатай холбон тайлбарласан байх юм. В нь хөрөнгө оруулалтын эрсдэлтэй зэрэглэл бөгөөд Монгол Улсын эдийн засаг байгалийн баялагт тулгуурласан, үйлдвэрлэгч орон биш зэрэг нь эдийн засагт санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдлыг бий болгож, улмаар энэ нь эрсдэлтэй орны тоонд багтах гол нөхцөл болсон байгаа юм. Ямартай ч, Дэлхийн банк, НҮБ манай улсыг хөгжингүй улсын тоонд багтаачихдаг байхад бид өөрсдөө ядуу буурай хэмээн “хашгирах” нь зөв үү.

Эсрэг тэсрэг байр суурь

ХЭН НЬ “ЧОНЫН АРЬС” НӨМӨРСӨН БАЙСНЫГ ЦАГ ХУГАЦАА ХАРУУЛНА

Б.Чойжилсүрэн: “Сайн хөтөлбөр” –үүд хууль зөрчиж байгаа тул зогсоосон

З.Нарантуяа: “Сайн хөтөлбөр” –үүдийг зогсоосон нь бодлогын алдаа

/Сангийн сайд/

/УИХ-ын гишүүн/

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нар төсвийн асуудлаар мэдээлэл хийхдээ ийн ярих.

Сангийн сайд Б.Чойжилсүрэн: 2016 оны төсвийг батлахдаа орлогыг долоон их наяд 13 тэрбум, зарлагыг долоон их наяд 953 тэрбум төгрөг байхаар тооцож оруулсан. Гэвч орлого нэг их наяд 10 тэрбум орчмоор буурч, таван их наяд хоёр тэрбум орчим болсон. Гэтэл зарлага 2.3 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний алдаа нь экспортын бараа бүтээгдэхүүний үнийг буруу тооцсонтой холбоотой. Зарлагыг дэлгэрүүлбэл, тэтгэврийн нэмэгдэлд 61 тэрбум, шинээр батлагдсан хууль тогтоомж хэрэгжүүлэхэд 6.8 тэрбум, цалин нэмэгдүүлэх шийдвэрийн хүрээнд 97 тэрбум төгрөг гэх мэтээр нэмэгдсэн. Тодруулбал, хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт өгнө гэсэн боловч бүгдэд нь өгсөн учир одоо 143 тэрбум төгрөг дутаад байна. Үүнээс гадна төсөвт суулгагүй Засгийн газрын хөтөлбөрийг олноор хэрэгжүүлсэн нь төсөвт маш их хүндрэл учруулсан. Бид “Сайн хөтөлбөр”-үүдийн үр дүнг ойлгож байгаа. Гэхдээ санхүүжүүлэх эх үүсвэр байхгүй дээрээс нь Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын тухай, Өрийн удирдлагын тухай зэрэг хэд хэдэн хуулийг зөрчиж байгаа тул “Сайн хашаа”, “Сайн оюутан”, “Сайн малчин”, “Сайн хувьцаа” хөтөлбөрийг зогсоосон. Өмнөх Засгийн газар “Сайн хөтөлбөр”-үүдийг санхүүжилтийн эх үүсвэрийг 2016 оны улсын төсөвт тусгаагүй байсан. Ерөнхийдөө сонгуульд санал авах зорилгоор Монгол Улсын холбогдох хуулиудыг зөрчин хэрэгжүүлж эхэлсэн эдгээр хөтөлбөрт 596 тэрбум төгрөг зарцуулсан байсан.

Ж.Эрдэнэбат: Зарим төрийн албан хаагчдын цалинг бууруулна

/Монгол Улсын Ерөнхий сайд/

“Эдийн засгийн нөхцөл байдал нэлээд хүндхэн байгааг хүн бүхэн мэдэж байгаа. Бид худлаа хэлээд хэрэггүй, өөрсдийгөө хуураад явах шаардлагагүй гэж бодсон. Хэзээ ч бид гадны хөрөнгө оруулагчдыг хуурч чадахгүй. Үнэн бодит байдлаа мэдээлж байж эх үүсвэр босгож авдаг. Аливаа тоон мэдээллийг засч залруулснаар эдийн засагт учрах хохирол нь маш их. Тийм учраас бид эхний ээлжинд тоон мэдээллээ үнэн зөв, бодитойгоор гаргаж тавьсан. Цаашдаа гаргасан тоон мэдээлэлдээ үндэслэлд эдийн засгаа эрүүлжүүлэх эмчилгээ хийнэ. Эдийн засгийг сэргээхийн тулд олон улсын хөрөнгө оруулагчдыг татах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ипотекийн зээлийг үргэлжлүүлэх, төрийн албан хаагчдын цалинг бууруулж, төрийн албаны зардлыг багасгах гээд бүх зардлыг танана. Хүүхдийн мөнгөний тухайд анх төсөвт тусгахдаа зорилтот бүлэгт өгнө гэж тусгасан. Гэтэл сонгуулийн өмнө нийтэд нь хавтгайруулан өгснөөр одоо хүүхдийн мөнгө олгож чадахгүйд хүрээд байна. Төсвийн тодотголын хүрээнд халамжуудыг тодорхой зорилтот бүлгүүдэд өгөх чиглэлийг Засгийн газраас барьж ажиллана.

Сэтгүүлчийн дүгнэлт

Намууд хэт улстөржиж улсаа унагаах вий дээ

МАН-ын Засгийн газар байгуулагдаад сар гаруйн хугацаа өнгөрч байгаа ч томилгооноос хэтэрсэнгүй. Томилгоо эдүгээ ч үргэлжилж буй. Хийх ажилгүй, авдаг цалингүй, цаашид үргэлжлүүлэн ажиллах эсэх нь тодорхойгүй төрийн албан хаагчид эзгүй хойгуур ажлаас халчих байх гэж эмээгээд зуны дэлгэр цагт амарсан юмгүй чөдөртэй морь шиг ажил гэр хоёрын хооронд эрэгцэж өнгөрөөв. Дээр нь цалингүй. Цалингүй учраас орон сууцны зээлээ төлөх аргагүйд хүрч эхнээсээ байр сав, унаа тэргээ банкинд хураалгаад эхэлж. Ийн хямарч ядаж байтал Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилгосон Н.Баяртсайхан Төв

банкны дэд ерөнхийлөгчийг томилж тухай асуудлыг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны үеэр “Монгол Улсын валютын нөөц 400 сая ам.доллар байна” гэж мэдэгдсэн нь ард түмнийг мэл гайхаж, цэл хөхөрхөд хүргэв. Эргэлзэж ядаж байтал Сангийн сайд Б.Чойжилсүрэн үргэлжлүүлээд маш болчимгүй гэмээр мэдээллийг олон нийтэд зарлаж орхин нь тэр. Хариуцлага бүхий албан тушаалтнууд юу гэж хэлснийг дээр өгүүлсэн тул дахин нуруулах нь илүүц. Асуудал үүгээр дуусаагүй. УИХ-ын дарга асан З.Энхболд, Хотын дарга асан Э.Бат-Үүл нар “АН-ын барьж байсан Засгийн газар одоогийн гүйцэтгэх засаглалд валютын

1.3 тэрбум ам.долларын нөөцтэй дансыг хүлээлгэж өгсөн. Харин үүнийг харуулж, бүр 400 гаруй сая ам.доллар байна хэмээн олон нийтэд мэдэгдэл хийдэг Сангийн сайдыг анх удаа харлаа. Түүний энэ мэдэгдлээс болоод валютын ханш 150 төгрөгөөр өслөө. Үүнээс болж монголчууд хохирч байна. Хоёрдугаарт, улсын төсөв гэдэг бол өөр зүйл. “Сайн хөтөлбөр”-үүд бас өөр зүйл. Гэтэл улсын төсөвт хамааралгүй явж байсан ажлыг хамаатуулж, улс төрийн зорилгоор зогсоолоо. Шинэ Засгийн газар, Монголбанкны шинэ ерөнхийлөгч энэ мэтээр ажиллаж болохгүй” хэмээсэн нь ард түмнийг төөрөгдүүлж орхисон төдийгүй

улс төрийн намууд мэдэгдлээр өөр хоорондоо хэрэлдэж эхэллээ.

Өчигдөр гэхэд л Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга С.Эрдэнэ, УИХ-ын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны гишүүн З.Нарантуяа нар хэрүүлийг үргэлжлүүлэв. Маргааш асуудлыг хэн нэг нь дахин сөхөх биз. Эцсийн дүнд улс төрийн намуудын утгагүй улстөржилтөөс иргэд л хохирох юм даа. Цаг цагаараа байдаггүй. Хэн нь үнэн ярьж, хэн нь шоу хийж, хэн нь хонины арьс нөмөрсөн чоно байсан юм бэ гэдгийг ялгаад өгөх нь дамжиггүй.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

Ж.ГАНБАТ: ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЦАЛИНГ Л БУУРУУЛНА

М.ДАВАА

Төрийн албан хаагчдын цалинг бууруулж, төсөвт хэмнэлт хийхээр болсон талаар Ерөнхий сайд өнгөрсөн даваа гарагт мэдэгдсэн. Тиймээс энэ талаар Сангийн яамны төсвийн бодлогын газрын дарга Ж.Ганбатаас тодрууллаа.

-Ерөнхий сайд төрийн албан хаагчдын цалинг бууруулах гэж байгаа талаар мэдэгдсэн. Ямар албан тушаалтнуудын цалинг

хэдэн хувиар бууруулахаар болов?

-Сангийн яамаас төсвийн тодотгол боловсруулж байгаа. Төрийн өндөр болон улстөрийн албан тушаалтнууд, яамд, агентлагийн удирдах албан тушаалтнуудын цалинг тодорхой хувиар бууруулах тухай асуудал яригдаж байна. Асуудлыг ойрын үед Засгийн газарт танишуулж, УИХ-д өргөн мэдүүлэн. Орон нутгийн Засаг болоод ИТХ-ын дарга нар, нийслэлд агентлагийн даргаас дээш албан тушаалтнууд энэ хэмнэлтэд хамрагдана гэсэн үг. Харин эдгээрээс доош түвшний төрийн албаныхны цалин

хөндөгдөхгүй байх үүргийг Ерөнхий сайдаас өгсөн. Улс төрийн болон төрийн өндөр албан тушаалтнуудын цалинг 30 хувь, төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын цалинг 20 хувиар тус тус бууруулна.

-Ийн төрийн албан хаагчдын цалинг бууруулаа гэхэд төсөвт хэчнээн төгрөг хэмнэж чадах вэ?

-Энэ оны хувьд гурав орчим тэрбум төгрөг, ирэх жилд найм орчим тэрбум төгрөг хэмнэгдэнэ.

-Цалин бууруулахаас гадна үйл ажиллагааны зардлыг бууруулах асуудлыг ярьж



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН


байсан?

-Тэвчиж болох бүх зардлыг бууруулна. Үүнд гар утас, тэвээр шатахууны зардлыг бууруулж, тавилга эд хогшлыг худалдаж авахыг зогсооно.

Урсгал засварыг бууруулна. Зочин төлөөлөгч хүлээж авах зардлыг бууруулах арга хэмжээг авна. Гар утасны зардаас гэхэд жилдээ 100-200 сая төгрөг хэмнэнэ.

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

Сургалтын төлбөр өрхийн ТӨ



Б.ДАВААХҮҮ
Н.БАТЗАЯА

Зуны зугаатай өдрүүд аль хэдийнэ ард үлдэж, өглөө оройдоо сэрүүн сахи сэвэлзэх нь намар ойртон ирж буйг сануулах мэт. Их, дээд сургуулиуд ч үүдээ нээж, суралцагчдаа бүтгээд эхэлчихэж. Наадмын дараа намар гэж үг бий. Малчдын хувьд намар хахирган хүйтнийг өнтэй давах бэлтгэл хангах үе байдаг бол ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийг өнгөрсөн хавар тогссон хүүхдүүд тэдний эцэг эхчүүдийн тухайд хүүхдийнхээ сургалтын төлбөр, байрны зардлыг нь олох томоохон асуудалтай тулгардаг ч гэж хэлж болно. Тиймээс “Монголын мэдээ” сонин улсын эдийн засгийн байдал хүндэрч, данс улайсан энэ үед их, дээд сургуулийн сургалтын төлбөр ямар байгаа хийгээд эцэг эхчүүд хүүхдийнхээ сургалтын төлбөрийг нь бүрдүүлж буйг сонирхон энэ удаагийн дугаарын сурвалжлагаа бэлтгэлээ.

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

—Зээлийнхээ хугацааг сунгаж, дахин зээл авсан—

Их, дээд сургуулийн төлбөр нэмэгдэхгүй

Жил бүр л оюутны сургалтын төлбөр нэмэгдэж иргэдийн нуруунд хүнд ачаа нэмдэг жишиг тогтоод хэдэн жилийн нүүрийг үзжээ. Тиймээс манай сурвалжлах хэсэг юун түрүүнд Боловсролын яамыг зорьсон юм. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар Ж.Батсуурь томилогдоод удаагүй ч тэрбээр ажлаа авсныхаа дараахан их, дээд, сургууль коллежийн удирдлагуудтай уулзаж, 2016-2017 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийг хуучнаар нь хадгалах тохиролцоонд хүрч чадсан нь нийгмээс “Ажиллаж чадах хүн байна” гэх үнэлгээг аваад буй. Ямартай ч улсын эдийн засаг, иргэдийн амьдрал, аж байдал хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөлд сургалтын төлбөр нэмэгдэхгүй нь.

Өнгөрсөн онд 73980 оюутан төлбөрөө бүрэн төлж чадаагүй байна

2015-2016 оны хичээлийн жилд дээрх тооны оюутан сургалтын төлбөрөө бүрэн төлж барагдуулаагүй талаархи тоон мэдээлэл байна. Их, дээд сургууль, коллежийн сургалтын төлбөрийг сүүлийн жилүүдэд жил бүрийн хэрэглээний үнийн индекс, инфляцийн өөрчлөлттэй уялдуулан 5.0-20.0 хүртэл хувиар нэмэгдүүлсээр ирсэн. Улмаар 2015-2016 оны хичээлийн жилийн тайлангаас харахад төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн сургалтын төлбөр 1.0-2.9 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж ирсэн байх жишээтэй. Гэвч өнгөрсөн хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийн нийт 162199 оюутны 93 хувь болох 150980 оюутан хувийн зардлаар суралцахаас 49 хувь болох 73980 суралцагч хичээлийн

жилийн төгсгөлд сургалтын төлбөрөө бүрэн төлж чадаагүй гэсэн харамсалтай мэдээлэл байна. Үүнийг дагаад зарим сургуулиуд сургалтын төлбөрөө бүтгээр нь төлөх шаардлага тавьж байгаа сурагтай.

Эцэг эхчүүд банкны зээлээр хүүхдээ сургадаг

Манай сурвалжлах хэсэг Боловсролын яамнаас гарч, улсын томоохон их, дээд сургуулиудийг зорилоо. Бидний эхний өртөө Монгол Улсын Боловсролын их сургуулийн хичээлийн нэгдүгээр байр байв. Сургуулийн нэг давхраас эхлээд хүүхдээ дагуулсан эцэг эхчүүдийн цуваа сургалтын албаны өрөө рүү хөврөх аж. Хань самбар, багана зэрэгт шинээр элсэн суралцагчдад хэрэгцээт мэдээллийг бичсэн цаас наалттай байх бөгөөд эцэг эхчүүд сандал дээр тухалж, төлбөр төлсөн баримт зэргийг гартаа барьсан шинэхэн оюутнууд дугаарлан зогсоо харагдана. Нэг давхрын зүүн буланд суух ягаан цоохор цамцыг хайнгадуухан өмссөн дунд эргэм насны эмэгтэйтэй уулзсан юм. Түүнийг С.Нэргүй гэдэг. Ханхэнтий нутгаас тэрбээр хүүгээ сургуульд нь бүртгүүлэхээр нийслэл хотноо ирсэн нь энэ аж. С.Нэргүй эгч нутагтаа махны лангуу ажиллуулдаг бөгөөд энэ жил хүүгийнхээ сургалтын төлбөрийг бүрдүүлэх гэж багагүй мунгинаснаа хуучилсан юм. Тэрбээр “Хүү маань Хэнтий аймагт арванхоёрдугаар ангиа төгссөн. МУБИС-ийн Газарзүйн багшийн ангид суралцана. Багшийн сургуулийн төлбөр нэг сая 950 мянган төгрөг юм гэнэ. Хүүхдийнхээ сургалтын төлбөрийг олоогүй байгаа. Хөнгөлөлт бий юу гэж асуухаар хүлээж байна. Болохгүй бол банкны зээлийнхээ хугацааг сунгах санаатай. Манайд ер нь зээлгүй хүн байхгүй шүү

дээ. Өмнө нь авсан банкны зээлийнхээ 50 хувийг нь төлчихсөн учраас зээлийнхээ хугацааг дахин хоёр жилээр сунгадаг юм билүү гэж бодож сууна. Дахиж зээл авахаас өөр аргагүй. Зээлэхгүй л бол их хэмжээний мөнгө гар дээр бэлэн олдохгүй. Их, дээд сургуульд хүүхдээ сургана гэдэг хөдөөнийхөнд хэцүү. Сургалтын төлбөр өндөр. Дээр нь дотуур байр, хоол унднаас эхлээд зардал өндөртэй. Тэгэхээр төр, засгаас зарим зүйлийг харгалзаж, хөдөө орон нутгийн оюутнуудад хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай байна. Малчдад малчны зээл гэж бий. Харин бидэн шиг хүмүүс малчны зээлийг авч болдоггүй юм” хэмээн өгүүллээ. Үнэхээр ч С.Нэргүй гуайн хэлж буй шиг банкны зээлийнхээ хугацааг сунган дахин зээл авч буй иргэд цөөнгүй байгааг нуугаад яах вэ.

Ирэх намар С Нэргүй эгч маань яах юм бол доо.

Давхар зээлээр төлбөрийг нь бүрдүүлжээ

Бидний дараагийн уулзсан хүн бол Б.Нямдорж. Шаргалдуу даавуун дээл, орос хромон гутлаар гангарч, гэргийнхээ хамт суух ахимагдуу насны тэрбээр 2016-2017 оны хичээлийн жилд гурван оюутан сургах гэнэ. МУБИС-ийн Биений тамир, спортын их сургуульд бага охин нь элсчээ. Чөлөөт бөхөөр хичээллэдэг, улсын аварга охиныг нь тус сургуулийн захиргаа үнэлж, сургалтын төлбөрөөсөө 70 хувийг хөнгөлүүлэх эрхийн бичгээр шагнасан байна. Хэдий тийм ч гурвын гурван хүүхдээ дээд боловсрол эзэмшүүлэхийн

түлд Б.Нямдоржийнх тэтгэвэр, малчны зээлийг давхар авснаас гадна малын ашиг шимээс хумьж хурааснаа нийлүүлж байж арайхийн төлбөрийг нь гүйцэлдүүлсэн гэнэ. Тэрбээр “Манай охин Биений тамир, спортын их сургуульд урилгаар, 70 хувийн хөнгөлөлттэй суралцахаар болсон. Их баяртай байгаа. Сургалтын төлбөрийн үнэ нэмэгдсэн, эдийн засгийн хямралтай үед 70 хувийн хөнгөлөлттэйгөөр сурна гэдэг маш том боломж, их аз юм даа. Биений тамирын сургуулийн төлбөр хоёр сая 100 мянган төгрөг юм билээ. Хүүхдийнхээ төлбөрийг малынхаа ашиг шим, зээлээр л бэлдлээ. Малын үнэ их буурсан. Яах вэ, нэг үеэ бодвол харьцангуй гайгүй болсон. Гэхдээ л малын түүхий эд үнэд хүрэхгүй байна шүү дээ.” хэмээн халаглан ярьсан юм. Сурвалжлах багийн

дараагийн зогсоол МУИС байлаа. Тус их сургууль хоёр болон дөрөвдүгээр курсынхээ сургалтын төлбөрийг нэмсэн гэх мэдээлэл тарсан байсан учир хэвлэлийн төлөөлөгчтэй нь уулзаж хэд хэдэн асуултад хариулт авсан юм.

А.Пагамсүрэн: Энэ жил сургалтын төлбөрөө нэмээгүй

/МУИС-ийн хэвлэлийн төлөөлөгч/

—Энэ жил танай сургуулийн сургалтын төлбөр нэмэгдсэн үү?

—Манай сургуулийн сургалтын төлбөр нэмэгдээгүй. Өмнөх жилийн төлбөрөөрөө байгаа. Энэ жил сайд төлбөрийг нэмэгдүүлэхгүй байх талаар тушаал гаргасан. Тэр дагуу манай сургууль



MMINFO.

Тал нутгийн цахим мэдээлэл



ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

ӨСВИЙГ ХООСОЛЖ байна

төлбөрөө нэмээгүй. Мөн удирдах зөвлөлийн зургадугаар сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолоор 2016-2017 оны хичээлийн жилийн бакалаврын түвшний сургалтын төлбөрийг гүйцэтгэх хамгаалалт өөр өөр үнэтэй байгаа. Тухайлбал, Шинжлэх ухааны сургуулийн нэгдүгээр курсийн нэг багц цагийн төлбөр 80.200, хоёрдугаар курс 74.600, 3-4 дүгээр курс 64.600 төгрөгийн үнэтэй. Бусад салбар сургуулиудын цагийн төлбөр 46-96 мянган төгрөгийн хооронд бий.

сургуулийн төлбөр хэвээрээ байгаа.

-Оюутнуудад хөнгөлөлтэй суралцах боломж олгодог уу?

-Манай сургуулийн нэрэмжит тэтгэлэг байдаг. Бид бакалаврын түвшний суралцагчдын сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцаж буй шилдэг оюутныг урамшуулах, зарим мэргэжлээр элсэгчдийг дэмжих зорилгын хүрээнд тэтгэлэг олгодог. Мөн улсын чанартай олимпиадад амжилттай оролцож, медальт байр эзэлсэн оюутнуудад сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлдэг.

дүүсийн хандивласан мөнгөөр бэлдчихлээ.Талыг нь цалингийн зээлээр аргалах байх. Ямар ч байсан хүүхдээ мэргэжилтэй болгохыг хүсч байна. Айлын том учраас мэргэжил эзэмшиж дүү нараа авч явах ёстой гэж би боддог. Тиймээс том хүүхдээ их сургуульд заавал сургана. Гэхдээ их, дээд сургуулийн төлбөр энэ янзаараа байвал бидэн шиг хүмүүст их хүнд тусах юм. Одоо байгаа төлбөрийг нь л төлөх гэж л урд хормойгоороо хойд хормойгоо нохож байна шүү дээ. Хүүхдэд зөвхөн сургалтын төлбөр төлөөд болчихгүй. Автобусны мөнгө, шинэ хувцас авна гээд л зардал өндөр. Хүн бүр л хүүхдээ бусдаас дутаахгүйг хичээдэг. Оюутан хүүхэдтэй айлын зардал их юм байна. Одоо өөрсдөө биеэрээ мэдэрч байна. Сургалтын төлбөр оюутан хүүхэдтэй айл бүрийн том асуудал болсон байх.

төлбөрийг нь төлөх жишээтэй. Нэг талаас шууд зээлээд бэлэн мөнгөтэй болох нь сайхан. Гэвч хүү гэж айхтар юм байдаг. Үндсэн мөнгөн дээрээ давхар хүү төлнө шүү дээ. Хүү гэдэг чинь төрийн байгууллагын бага цалинтай хүнд амаргүй л дээ. Би сургуулийн эмч. Сарын 400 мянган төгрөгийн цалин авдаг. Нөхөр бид хоёр өмнө нь хоёр оюутан төгссөн. Дараа жил бас нэг оюутан нэмэгдэнэ. Тэгэхээр дараа жил хоёр оюутны төлбөр төлөх болж байгаа юм. Ямар нэгэн төлбөрийн хөнгөлөлт байхгүй. Хэцүү л байна. Ер нь их, дээд сургуулийн сургалтын төлбөрийг багасгах хэрэгтэй. Жил ирэх тусам л нэмэгддэг. Төлбөрөөс болж олон хүүхэд сургуульд сурч чадахгүй, эцэг эхчүүдийн нуруундаа үүрэх ачаа нь хүнд байгаа шүү дээ. Үүнийг тодорхой эрх мэдэлтэй хүмүүс нь ойлгох хэрэгтэй байх. Энгийн иргэд л зовж байна. Жил бүр гурван сая 500 мянган төгрөг гэдэг хатуу. Дараа жил хэд болж нэмэгдэхийг хэн ч хэлж мэдэхгүй шүү дээ.

байна. Хөнгөлөлт үзүүлээгүй бол ч хэцүү шүү. Би Хөвсгөл аймгийнх. Аймагтаа гутал хийдэг юм. Одоо хүн юм худалдаж авахаа больж. Авья гэсэн ч хүмүүст мөнгө нь алга байна шүү дээ. Малаар авья гэж байна. Малаар өгөхөөр мал нь эргээд мөнгө болохоо болчихсон байна. Гэхдээ яах вэ, гар хөдөлж байгаа болохоор гурван хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлчихлөө. Их, дээд сургуулийн төлбөр эцэг эхчүүдийн нуруун дээр маш том ачаа болж байна. Нэг их өндөр үнээр сурдаг. Гэтэл төгсөөд ажилтай болж байгаа нь хэд билээ. Би одоо гурван хүүхдээ ажилтай болоосой л гэж хүсч байна. Ямартай ч төлбөрийг нь хийчихлээ. Төлж чадахгүй олон хүн байгаа байх.

маань сургалтын төлбөрийг ах нь төлнө гэсэн. Манай хүү ажил хийдэг юм. Тэтгэврийн насныханд хүүхдийнхээ сургалтын төлбөрийг хийнэ гэдэг хэцүү. Их хүнд ачаа болдог юм. Үүнийг оюутан хүүхэдтэй эцэг эх бүр л мэдэж байгаа байх. Төр, засгаас сургалтын төлбөрийг бууруулах эсвэл онцгой хөнгөлөх арга хэмжээ аваасай гэж хүсч байна. Зарим сургууль өндөр оноо авбал хөнгөлнө гэсэн. Үнэхээр хүүхэд сурах сонирхолтой хэдий ч өндөр оноо авч чадахгүй бол яах вэ. Өнөөдөр элсэлтийн ерөнхий шалгалт огч байгаа хүүхдүүдийн хэд нь өндөр оноо авч байгаа бол. Өндөр оноо авч байгаа хүүхдүүд нь цөөхөн л байх. Хүн бүр л хүүхдээ мэргэжилтэй болгохыг хүсдэг. Тэгэхээр хүүхдүүдийг ялгалгүй нэгдсэн журмаар сургалтын төлбөрийн асуудлыг шийдээсэй гэж хүсч байна.

...Төлбөр нь нэмэгдээгүй байна. Гэвч бид төлж чадахааргүй л байна. Тал төлбөрийг нь өөрсдийн цуглуулсан, ах дүүсийн хандивласан мөнгөөр бэлдчихлээ. Талыг нь цалингийн зээлээр аргалах байх. Ямар ч байсан хүүхдээ мэргэжилтэй болгохыг хүсч байна. Айлын том учраас мэргэжил эзэмшиж дүү нараа авч явах ёстой гэж би боддог. Тиймээс том хүүхдээ их сургуульд заавал сургана. Гэхдээ их, дээд сургуулийн төлбөр энэ янзаараа байвал бидэн шиг хүмүүст их хүнд тусах юм...

Бид ийн ярилцсаныхаа дараа Анагаах ухааны Үндэсний их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийг зорьсон юм.

Б.Дулмаа: Сургалтын төлбөр нэмэгдээгүй ч бид төлж чадахгүй юм

Ц.Оюунцэцэг: Цалингийн зээл авсан

/Завхан айлгийн иргэн/

-Би төрийн байгууллагад ажилладаг. Манай хүүхэд МУИС-ийн эдийн засгийн ангид суралцана. МУИС-ийн сургалтын төлбөр гурван сая 500 мянга гэж байна. Хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөхийн тулд таван сая төгрөгийн цалингийн зээл авлаа. Манайх Завханых учраас хүүхдээ байранд суулгах шаардлагатай. Тиймээс таван сая төгрөгийн зээл авсан юм. Миний бодлоор монголчууд хүүхдээ их сургуульд сургахын тулд өрөнд баригдаж дуусдаг юм шиг санагддаг. Би л гэхэд цалингийн зээл авч байж

н.Бат-Эрдэнэ: Их сургуулийн төлбөр маш том ачаа болж байна

/Хөвсгөл айлгийн иргэн/

-Манай гурван хүүхэд Анагаахын их сургуульд сурдаг. Гурван хүүхдийн төлбөрийг зэрэг төлнө гэдэг хэцүү. Нэг хүүхдийнхээ төлбөр болох хоёр сая 700 мянган төгрөгийн сая тусаалаа. Сая захирал дээр нь орж "Манай гурван хүүхэд сурдаг хөнгөлж өгөөч" гэж хэлтэл зөвшөөрч

н.Солонго: Аав маань цалингийн зээл авсан

-Би Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуульд сурдаг. Манай сургуулийн төлбөр энэ жил нэмэгдээгүй байна лээ. Кредит нь 65 мянга 500 төгрөг байдаг. Хэвээрээ байна. Миний сургалтын төлбөрийг аав маань цалингийн зээл авч хийсэн.

Ц.Эрдэнэчимэг: Сургалтын төлбөрөө олоогүй

-Миний охин МУБИС-ийн Багшийн сургуульд орно. Төлбөрийг нь наймдугаар сарын 25-ны дотор хий гэсэн. Одоо болтол төлбөрөө олоогүй байгаа. Юу ч гэсэн бүртгүүлэх санаатай явж байна. Би тэтгэврийн хүн. Охины

Ц.Оюунчимэг: Малчны зээл авсан

/Завхан айлгийн иргэн/

Манайх Завхан аймагт амьдардаг, малчид. Охин маань энэ жил оюутан болсон. Бага ангийн багш мэргэжлээр сурна. Бид охиныхоо сургалтын төлбөрийг төлөхийн тулд дөрвөн сая төгрөгийн малчны зээл авсан. Малчны зээлийн хүү 18 хувь. Бидний санхүүгийн гол эх үүсвэр мал шүү дээ. Тэгэхээр малынхаа арьс, ноос, сүү цагаан идээг зарж л мөнгө олно. Тэгж байж л зээлээ төлнө. Жил ирэх тусам малын бүтээгдэхүүний үнэ унаж байна. Энэ нь малчин бидэнд их хүндээр тусч байгаа. Орлогын эх үүсвэр маань л жилээс жилд байхгүй болж байна. Малчны хүүхэд ч гэсэн сургуульд сурч, мэргэжил эзэмшинэ. Тэгэхээр дөрвөн жил л сургалтын төлбөр төлөх шаардлагатай. Энэ жилийнхээ зээлийг төлж амжаагүй байтал дараагийн жилийн сургалтын төлбөр нэхэгдэх байх даа.

Д.Энхзаяа: Гурван сая 500 мянган төгрөг зээллээ

Би төрийн албанд ажилладаг болохоор гурван сая 500 мянган төгрөгийн цалингийн зээл авсан. Нөхөр маань ажил хийдэггүй. Ганц хүнд гурван сая 500 мянган төгрөгийн зээл гэдэг чангал тусч байна. Гэхдээ яах вэ хүүхдээ сургах ёстой учраас ёстой л бүсээ чангалаад л зүтгэлээ. Их, дээд сургуулийн сургалтын төлбөрийг багасгах хэрэгтэй гэж бодож байна. Тэгэхгүй бол ихэнх энгийн иргэд бага цалингаар ажилладаг учраас цалин нь сургалтын төлбөрт хүрэлцэхгүй байна.



-Хоёр болон дөрөвүгээр дамжааны төлбөр нэмэгдсэн гэсэн. Энэ үнэн үү?

-Үгүй. Шинжлэх ухааны сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургуульд нэг багшийн нэг хичээл хоёр өөр төлбөрөөр ордог байсан юм. Өөрөөр хэлбэл, математик гэдэг хичээл Шинжлэх ухааны сургуульд 70.200, Хэрэглээний шинжлэх ухааны сургуульд 80.100 мянган төгрөгийн төлбөртэй заагддаг байсан гэсэн үг. Үүнийг бид өөрчилж, тогтсон нэг үнэтэй болгосон. Төлбөр нэмсэн асуудал байхгүй. Манай

ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ
Онцгой урамшуулал

ХУДАЛДАН АВАЛТ БҮРТ eMart ДЭЛГҮҮРЭЭР ҮЙЛЧЛҮҮЛЭХ 50,000₮-НИЙ ВАУЧЕР БЭЛЭГЛЭНЭ.

Цүнх + 2 жилийн баталгаа + McAfee SECURE Вирусын програм

Ваучерийн тоо хязгаартай

ДЭЛХИЙ

НҮБ-ЫН ТЭРГҮҮНЭЭР ЭМЭГТЭЙ ХҮН СОНГОГДОХ УУ

Б.ДАВАА

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүний бүрэн эрхийн хугацаа энэ оны сүүлээр дуусах билээ. Ажлаа хүлээлгэн өгөх хугацаа нь ойртож буй НҮБ-ын тэргүүн өөрийн залгамжлагчаа эмэгтэй хүн байгаасай гэж хүсч буйгаа илэрхийлсэн тухай “Ассошэйтэд пресс” агентлаг уламжилжээ. Тэрбээр “НҮБ-ын тэргүүнээр эмэгтэй хүн ажиллавал сайнсан” гэж хэлсэн байна. Түүний хувьд өнөөгийн цаг үед НҮБ-ыг эмэгтэй хүн жолоодох нь илүү дээр гэж үзэж буй бололтой. “Бидэнд олон улсын засгийн газар, бизнес, улс төр, олон нийтийн шилдэг эмэгтэй удирдагчид байна. Би Нэгдсэн Үндэстний Байгууллагын тэргүүн яагаад эмэгтэй хүн байж чадахгүй байх шалтгааныг олж хархгүй байна” хэмээн Бан Ги Мүн мөн нэмж хэлжээ. 70 жилийн түүхэнд НҮБ-ыг нийтдээ найман хүн удирдаж байсан бөгөөд тэд бүгд эрчүүд байсан гэдэг. Тус байгууллагын дүрэмд Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгохдоо жендерийн тэгш байдлын зарчмыг баримтална хэмээн тусгасан байдаг аж.

Тодруулбал, НҮБ-ын тэргүүнээр сонгогдоход эрэгтэй, эмэгтэй хүмүүст ижил боломж үйлчилдэг гэсэн үг юм. Харамсалтай нь НҮБ-ын түүхэнд нэг ч эмэгтэй дарга сонгогдож байгаагүй. Харин энэ удаа түүхэндээ анх удаа эмэгтэй хүн сонгогдох магадлалтайг шинжээчид онцолж байна. Ялангуяа өмнө нь нэг ч удаа сонгогдож байгаагүй зүүн Европын бүс нутгаас НҮБ-ын дарга тодрох магадлал маш өндөр байгаа гэнэ. Учир нь ерөнхий нарийн бичгийн даргын суудлыг дэлхийн бүс нутгууд эзлэн барьдаг уламжлалтай. Ази, Африк, Латин Америк, Баруун Европын орнууд бүгд НҮБ-ын тэргүүнээр өөрийн төлөөлөгчийг ажиллуулж байсан ч, Зүүн Европоос нэг ч хүн томилогдож байгаагүй юм. Ямартай ч, тус байгууллагын тэргүүнээр хэн сонгогдохыг Бан Ги Мүн шийдэхгүй. Эл шийдвэрийг Аюулгүй зөвлөлийн 15 гишүүн гаргаж, 193 гишүүнтэй Ерөнхий Ассамблейгаар хэлэлцүүлэн



батлуулах учиртай. Одоогийн байдлаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалд нийтдээ 11 хүн нэр дэвшиж байгаа бөгөөд тэдний дотор таван эмэгтэй байгаа юм. Дашрамд дурьдахад, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс 12 нэр дэвшигчдийн дунд албан бус хоёр санал хураалт явуулахад өндөр магадлалтайд тооцогдож буй эмэгтэй нэр дэвшигчид хоёулаад нь саналаараа гуравт орж байжээ. Эхний санал хураалтад НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын тэргүүн асан Болгарын иргэн Ирина Бокова гуравт орсон бол хоёр дахь санал хураалтаар Аргентиний

Гадаад хэргийн сайд Сюзана Малкорра мөн гуравт оржээ. Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын өрсөлдөөнд Шинэ Зеландын Ерөнхий сайд асан Хелен Кларк, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн тэргүүн асан Кристиа Фигуэйрес, Молдавын Гадаад хэргийн сайд асан Наталья Герман нарын хүмүүс нэр дэвшээд байна. Аюулгүйн зөвлөл энэ сарын сүүлчээр дахин санал хураалт явуулах бөгөөд ирэх есдүгээр сард дахин хоёр удаа санал хураах юм байна. Ямартай ч, энэ оны эцэс гэхэд Бан Ги Мүнийг эмэгтэй хүн залгамжлах эсэх нь шийдэгдэх юм.



Theguardian. БОКСЫН СПОРТ АВЛИГАД ИДЭГДЖЭЭ

Хүн төрөлхтөний эв нэгдлийн бэлгэдэл болсон Олимпын Хаанадам Бразилийн Рио де Жанейро хотноо зохион байгуулагдаж, 205 орны 10 мянга гаруй тамирчид спортын 28 төрлөөр өрсөлдөж байгаа билээ. Гэвч зарим спортын төрлийн тэмцээний шүүлт илт нэг талд үйлчилж байгаа нь олон орны иргэдийн уур бухимдлыг төрүүлээд буй. Худал хуурмаг шүүлт манай улсын тамирчдыг ч тойрсонгүй. Олон улсын хэмжээний мастер Д.Отгондалай мөнгөн медалийн төлөөх тоглолтод луйвардуулж, Олимпын хүрэл медаль дээр буусан. Тэгвэл “theguardian” сонин Олимпын боксийн тэмцээн авлигад идэгдсэн тухай мэдээллийг нийтэлж, шүүгчдийн булхайг илчиллээ. Тус мэдээлэлд “...Спортын хүрээний томоохон албан тушаалтнууд нэр бүхий боксчдыг ялуулахын тулд эрх мэдлээ ашиглан бусад албаны хүмүүстэй хийвалдаж, шүүлтийн тогтолцоог дур зоргоороо залуурдаж байна. Нэгэн эх сурвалжийн хэлж буйгаар Рио-2016 наадмын зарим шүүгчид ч авлига авчээ.

Шүүгчид баг бүрдүүлж, аваргын төлөөх тоглолт гэх мэт томоохон тоглолтын өмнө уулзаж, шүүлтгүйг хэрхэн явуулахаа шийддэг аж. Сүүлийн жилүүдэд Олимпын үеэр маргаантай хэд хэдэн тоглолт болсныг уншигчид санаж буй биз. Тэднээс хамгийн гутамшигтай нь 1988 оны Сөүлийн Олимпын үеэр зохион байгуулагч орны тамирчин Пак Си-Хун Америкийн тамирчин Рой Жонс Жунниорийг шүүгчийн шийдвэрээр ялсан нь шуугиан тарьж байсан билээ. Олон улсын боксын холбооны дэд ерөнхийлөгч асан Рудель Обрежа 2008 оны Бээжингийн Олимпын үеэр шүүгчийн шийдвэрийг өөрчилсөн хэрэгт мөн сэжиглэгдсэн. Энэ хэрэгтэй холбоотойгоор тэрбээр энэ долоо хоногт ОУБХ-ноос гарсан байх магадлалтай. Мөн нэрээ нууцалсан эх сурвалжийн хэлснээр, Лондоны наадмаас хойш авлигын хэрэг улам боловсронгуй болж, өргөн хүрээг хамрах болсон аж.

Тодруулбал, өмнө нь авлига авч байсан хүмүүс тоглолтын раунд бүрийн төгсгөлд шүүгчдийг удирдахын тулд гар болон толгойгоороо дохно өгдөг бөгөөд үүний дагуу шүүгчид аль булангийн тамирчныг ялуулахаа шийдвэрлэдэг байж. Харин энэ аргыг олон тэмцээнд ашигласны дараа хуучирч, тэд энэ хэлбэрээ өөрчилж, томоохон тоглолтын өмнө уулздаг болжээ. “Энэ ажиллагаа маш нууцлаг явагддаг. Зарим тохиолдолд илт мэдэрдэг бөгөөд ийм бохир явдлыг хараад үнэхээр их уур хүрдэг” хэмээн хэлснийг энд дурьдах хэрэгтэй болов уу...” гэжээ.

АНУ-ын Армийн штабын дарга БНСУ-д айлчилна

АНУ-ын Армийн штабын дарга, генерал Марк Милли энэ долоо хоногт БНСУ-д айлчлахаар болсон тухай тус улсын Баглан хамгаалах яамнаас мэдээллээ. Генерал Марк Миллигийн айлчлал өнөөдрөөс эхлэн гурван хоног үргэлжлэх юм байна. Энэ үеэр тэрбээр пуужингийн довтолгооноос хамгаалах “THAAD” системийг БНСУ-ын нутаг дэвсгэрт байрлуулах төлөвлөгөөний тухай мэдээллийг БНСУ-ын талаас авах ажээ. Генерал Марк Милли 2015 оны наймдугаар сард Армийн штабын даргаар сонгогдсоноосоо хойш хоёр дахь удаагаа БНСУ-д айлчилж байгаа нь энэ юм. АНУ-ын “THAAD” системийг БНСУ-ын нутаг дэвсгэрт байрлуулах шийдвэртэй холбоотой асуудал олны анхаарлыг татаад байгаа энэ үед АНУ-ын Армийн томоохон албан тушаалтан Өмнөд Солонгост айлчлахаар болж байна. АНУ болон БНСУ-ын гаргасан энэ шийдвэрийг Өмнөд Солонгосын иргэний бүлгүүд, сөрөг хүчний хууль тогтоогчид төдийгүй БНХАУ, ОХУ зэрэг улсууд мөн л эрчимтэй эсэргүүцэж байгаа билээ.

Нарендра Модди 20 сая ОО-ыг шинээр барьжээ

Энэтхэгийн Тусгаар тогтнолын өдөр энэ сарын 15-нд тохиосон билээ. Тэгвэл энэ өдрөөр ард иргэддээ хандан илтгэл тавьж, өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах үеэр тус улсын Ерөнхий сайд Нарендра Модди Засгийн газраас өнгөрсөн хоёр жилийн хугацаанд улс даяар нийтдээ 20 сая гаруй жорлонг шинээр барьсан тухай мэдээлжээ. 17 дугаар зууны үеийн хуучны барилга

Ред Фортын ордонд тэрбээр илтгэл тавьсан байна. Дэлхийн хамгийн олон хүн амтай хоёр дахь улс болох Энэтхэгт бүс нутгийг цахилгаанаар хангахаас гадна жорлонгийн асуудал хурцаар тавигддаг гэдгийг тэрбээр илтгэлийнхээ үеэр онцолжээ. Нарендра Модди Ерөнхий сайдын албан тушаалд томилогдсоныхоо дараахан буюу одоогоос хоёр жилийн өмнөх Тусгаар тогтнолын баярын өдрөөр тавьсан

илтгэлдээ бэлгийн хүчирхийлэл болон жорлонгийн хүрэлцээ муу гэх мэт асуудлыг шийдвэрлэхээ амлаж байсан бөгөөд тухайн үед дөрвөн жилийн дотор бүх бүс нутгийг стандартын жорлонгоор хангаж ажиллахаа амласан байдаг.

Ямартай ч, саяхан болж өнгөрсөн үндэстний баярын өдрөөрөө Модди “Бид маш богино хугацаанд Энэтхэгийн тосгодод нийтдээ 20 сая гаруй жорлонг барьж байгуулсан

байна” хэмээгээд нийт ард иргэддээ баяр хүргэсэн байна. Энэтхэгийн хувьд олон жилийн турш жорлонгийн хүрэлцээ болон эрүүл ахуйн байдал нь эрх баригчдын шүдний өвчин болж байсан юм. НҮБ-ын Хүүхдийн төлөө сангийн мэдээллээр хүн амынх тал хувь нь буюу 594 сая хүн гадаа бие засдаг байжээ. Харин Нарендра Модди Ерөнхий сайдаар томилогдсоноос хойш эл асуудалд анхаарч ажиллах болсон аж.

Москвад их хэмжээний хур тунадас оржээ

Ширүүн бороо үргэлжлэн орсны улмаас ОХУ-ын нийслэл Москва хотноо үерийн гамшиг нүүрлэжээ. Тус улсын орчны шинжилгээний хүрээлэнгээс мэдээлснээр энэ сард орсон хур тунадасны хэмжээ өнгөрсөн 129 жилд байгаагүй хэмжээнд хүрч, олон жилийн дунджийг давсан байна. Тодруулбал, Москва хотод орсон хур тунадасны хэмжээ 48 мл-ыг давж, 1887 онд оноос хойшхи хамгийн их хэмжээнд хүрчээ. Хот доторхи замууд усанд автснаас гадна зүүн хойд хэсэгт орших Москва гол үерлэж, метроны буудал усанд автсан байдалтай байгаа тухай барууны сайтууд мэдээллээ. Үүнээс гадна Онцгой байдлын хэлтсийн алба хаагчид хотын өмнөд хэсгийн зам усанд автсаны улмаас суудлын машин болон автобустай усанд саатсан 80 орчим иргэнийг аварч, аюулгүй газарт хүргэсэн байна. ОХУ-д энэ сарын 14-ний өдрөөс эхлэн ширүүн бороо үргэлжлэн орж байгаа аж.



ТӨЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭ

Дүгнэж түүрвэл байгаа Улаанбаатар хотноо дүгнэж байгаа санхүүжилтүүс өөрсөрт нэртэй хүн...

Түгшүүр үг

MMINFO.MN сайтаас

06 сарын 30 (Давса) Улаанбаатар 14°C

Цахим мэдээ 30 минутын өмнө шинэчлэгдсэн

Орос, Монгол найрамдлын илэрхийлэл Звериний тоглолт тун удахгүй

Дэлгэрэнгүй мэдээллийг MMINFO.MN сайтаас

ШУУРХАЙ МЭДЭЭ

С.САЙНБАЯР: СҮХБААТАР ДҮҮРГИЙН 500 ГАРУЙ ХҮҮХЭД ЦЭЦЭРЛЭГТЭЙ БОЛНО

Ж.ӨӨДЦӨН

Хэдхэн хоногийн дараа хичээлийн шинэ жил эхэлж, сургууль, цэцэрлэг цуглах гэж байна. Тиймээс хотын төвийн дүүрэг болох Сүхбаатар дүүргийн сургууль, цэцэрлэгүүдийн засвар дууссан эсэх талаар тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга С.Сайнбаяраас тодрууллаа.

-Хэдхэн хоногийн дараа хичээлийн шинэ жил эхлэх гэж байна. Сургууль, цэцэрлэгийн байрны засвар үйлчилгээ ямар шатандаа байна вэ?

-Сүхбаатар дүүргийн тухайд 2016-2017 оны хичээлийн жилд төрийн өмчийн 26, төрийн бус өмчийн 24 сургуульд нийтдээ 34 мянга гаруй хүүхэд хамрагдана. Энэ жил төлөвлөсөн сургууль, цэцэрлэгийн засвар үйлчилгээ өнөөдрийн байдлаар 90 орчим хувьтай явагдаж байна. Эхнээсээ зарим сургууль, цэцэрлэгийн засвар дуусаад их цэвэрлэгээ хийгдэж байгаа. Хамгийн гол нь засварын ажил чанартай хийгдэх явдал. Хөрөнгө оруулалт ямар нэгэн саадгүй хийгдсэн учраас засварын ажлын чанар сайн үзүүлэлттэй байна.

-Сургууль, цэцэрлэгүүдэд ямар засвар хийгдэж байна. Монгол хэл, бичгийн кабинетуудыг тохижуулна гэж байсан?

...Энэ жил дөрвөн цэцэрлэгийн барилгыг шинээр өргөтгөн шинэчлэх ажлыг хийж байна. Тухайлбал, улсын төсвийн хөрөнгөөр 150 хүүхдийн ортой нэгдүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга баригдаж байгаа...

-Энэ жил дүүргийн төрийн өмчийн 32, төрийн бус өмчийн 36 цэцэрлэгт нийтдээ 11 мянга гаруй хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшинэ.

Бид төлөвлөгөөний дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтаар сургууль, цэцэрлэгүүдэд сантехникийн болон дэвэр, гадна фасадын засвар хийж байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн технологийн эрэгтэй, эмэгтэй кабинетад тоног төхөөрөмж, сургалтын хэрэгсэл суурьлуулж байгаа. Түүнчлэн Монгол хэл, бичгийн кабинетийг тохижуулах, үндэсний ёс заншлын танхимд тоног төхөөрөмж нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

-Танай дүүрэг улсдаа анх удаа орон нутгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэг барьсан гэсэн. Хэдэн цэцэрлэг барьсан юм бэ?

-Манайх хотын төвийн дүүрэг учраас сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сүүлийн дөрвөн жил нэлээд анхаарч ажилласан. Энэ зорилтынхоо хүрээнд дүүргийн хөрөнгөөр өнгөрсөн жил XVI хороонд 240 хүүхдийн ортой 225, X хороонд мөн 240 хүүхдийн ортой 234 дүгээр цэцэрлэгийг тус тус барьж ашиглалтад оруулсан. Энэ бол дүүргийн Засаг даргын Тамгын газрын боловсролын салбартаа оруулсан томоохон хөрөнгө оруулалтын нэг нь гэж хэлж болох юм.

-Хэд хэдэн цэцэрлэгийн барилгыг өргөтгөж шинэчилж байгаа гэсэн үү. Өргөтгөн шинэчлэлийн ажил дууссан уу?

-Энэ жил дөрвөн цэцэрлэгийн барилгыг шинээр өргөтгөн шинэчлэх ажлыг хийж байна. Тухайлбал, улсын төсвийн хөрөнгөөр 150 хүүхдийн ортой нэгдүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга баригдаж байгаа. Ирэх есөн сардаа багтаагаад ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн дүүргийн XIII хороонд 75 хүүхдийн ортой шинэ цэцэрлэгийн барилгын ажил хийгдэж байна. Түүнээс гадна Япон улсын Засгийн газрын тусламжтайгаар дүүргийн VII хорооны нутаг дэвсгэрт 150 хүүхдийн ортой 135 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн шинэ барилга баригдаж байгаа. Мөн Дэлхийн эон ОУ-ын байгууллагын тусламжтайгаар XVIII хорооны нутаг дэвсгэр буюу Балхад 166 дугаар цэцэрлэгийн 25 хүүхдийн ортой өргөтгөлийн барилгын ажил 90 хувьтай явж байгаа. Энэ дөрвөн цэцэрлэг ашиглалтад орсноор нийтдээ 500 гаруй хүүхэд шинээр сургуулийн өмнөх боловсрол эзэмших боломж бүрдэх юм. Ингэснээр тэдний аав, ээж нь ажил хийж, орхирин орлогоо нэмэгдүүлэх сайн талтай.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

САМАР ТҮҮХЭЭР ЯВААД, МОДНООС УНАЖ АМИА АЛДЖЭЭ

Жил бүр хушны самрыг хууль бусаар бэлтгэх асуудал яригддаг. Иргэд хушны самрыг гүйцэтгэж боловсроогүй үед нь түүж түүнийгээ борлуулдаг. Ийнхүү бэлтгэхдээ иргэд өөрийгөө болон өрөөлийг бэртээн, амь нас, эрүүл мэндээрээ хохирдог билээ. Энэ жилийн тухайд ч Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум зургадугаар багийн нутаг Тоом гэх газарт самар түүж явсан 28 настай эрэгтэй Э модноос унаж нас барсныг шалгаж байна. Иргэдэд сануулахад Ойн тухай хуулиар хууль бусаар бэлтгэсэн, тээвэрлэсэн тохиолдолд, олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тус тус төгрөгөөр торгоно гэж хуульчилсан байдаг. Тиймээс иргэдийг захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг хууль бус үйлдлийг хийхгүй байхыг цагдаагийн байгууллагаас анхааруулж байна.

Гачууртаас Яармагийн гүүр хүртэл завьт эргүүл ажиллаж байна

Иргэдийг усны ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, тусламж үзүүлэх, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газраас 21 хоногийн "Болзошгүй усны ослоос урьдчилан сэргийлэх" удирдамжийн дагуу нийслэлийн Онцгой байдлын газрын даргын тушаал гарсан байна. Усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг энэ сарын 05-26 өдрүүдэд зохион байгуулж байгаа аж. Нийслэлийн хэмжээнд Туул гол

дагуу буюу Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо Гачууртын Хадан цохионоос Хан-уул дүүргийн нутаг яармагийн гүүр хүртэл Нийслэлийн Онцгой байдлын газар, дүүргүүдийн Онцгой байдлын хэлтэс, Нийслэлийн аврах анги, Гал унтраах аврах ангийн нийт 103 албан хаагч, 14 техник хэрэгсэлтэйгээр өдөр бүр эргүүлд гарч байгаа юм байна. Мөн Завьт эргүүл зургаадугаар сарын 20-ны өдрөөс есдүгээр сарын 20 хүртэл Туул гол дагуу эргүүлээр ажиллаж байгаа юм.

PHOTO NEWS



2014 онд байгуулсан халтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын Төрийн архивын удирдах газрын төлөөлөгчид Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо 2016 оны наймдугаар сарын 15-19-ний өдрүүдэд албан айлчлал хийх гэж байгаатай холбогдуулан "МОНГОЛ-ХЯТАДЫН ТҮҮХЭН ХАРИЛЦАА /1949-2016/" сэдэвт архивын барилт, кино, гэрэл зургийн үзэсгэлэн өчигдөр нээгдлээ. Үзэсгэлэнд улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, шинжлэх ухаан, бүтээн байгуулалтын холбогдолтой архивын барилт, кино, гэрэл зургийг дэлгээн үзүүлж, барилтыг монгол хятад хэлээр тайлбарлаж байна.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Сургууль, цэцэрлэгийн засварын явцтай танилцлаа

Нийслэлийн Удирдах ажилтнуудын ээлжит Шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн Засаг даргын өгсөн үүргийн дагуу 2016-2017 оны хичээлийн шинэ жил эхлэх гэж байгаатай холбогдуулан нийслэлийн төвийн зургаан дүүргийн сургууль, цэцэрлэгийн барилгын засварын ажлын явц болон бэлтгэл ажилтай нийслэлийн Засаг даргын Гэр хорооллын хөгжил, нийгмийн асуудал хариуцсан орлогч Ш.Анхмаа, нийслэлийн Засаг даргын Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан орлогч Д.Энхтөр, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга М.Отгонбаяр нар газар дээр очиж танилцаж байгаа аж.

Хотын төвийг шарилжаас салгаж эхэлжээ

Нийслэлийн иргэдийг шарилжаас үүдэлтэй харшлаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Шарилжгүй Улаанбаатар" аян өрнөж буй. Энэхүү аян нийслэлийн дүүрэг бүр өрнөж байгаа бөгөөд Баянзүрх дүүргийн хувьд шарилж устгалын ажлыг "Нийтлэг үйлчилгээний газар I, II, III, IV"-тай хамтран зохион байгуулж, шарилж болон харшил үүсгэгч ээрлэг ургамлыг түүж, устгаж эхэлсэн байна. Тухайлбал, Нийтлэг үйлчилгээний газар II дүүргийн 3.13 хороо, Дунд гол, офицеруудын ордон, Энхтайваны гүүрээс баруун тийш Замын цагдаагийн газрын фризёр хүртэлх талбайн шарилжийг цэвэрлэсэн аж.

Булган аймгийн Тэшиг сум руу зорчихгүй байхыг зөвлөж байна

Онцын шаардлагагүй бол Булган аймгийн Тэшиг сум руу зорчихгүй байхыг албаныхан зөвлөж байна. Учир нь энэ сарын 13-нд орсон хур борооны улмаас Тэшиг сумын Харгал багийн нутаг Эгийн голын усны түвшин ихэсч, гүүрний хоёр талын үерийн далан сэтгэрчээ. Үүний улмаас тээврийн хэрэгсэл, явган хүн зорчих боломжгүй болсон байна. Өчигдрийн байдлаар тус аймгийн Онцгой байдлын газрын алба хаагч нар Эгийн голоор нийт 85 хүн завир гарган ажиллажээ.

ХӨСҮТ-д хоёр сарын хугацаат үүрэг өглөө

Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг болон яамны удирдлагын зөвлөл ХӨСҮТ, ХСҮТ-ийн үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудалтай танилцлаа. ХӨСҮТ-д үндэсний хэмжээнд халдварт өвчний тандалт, хяналт, эмчилгээ, оношилгоо, ялангуяа бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэ өвчнийг бууруулах, байгууллагын удирдлагын менежмент, эмч, мэргэжилтнүүдийн хариуцлага,

ёс зүйг сайжруулах зэрэг асуудал тулгамдаж байгаа аж. Тиймээс эдгээр асуудлуудыг шийдвэрлэх талаар ажлын төлөвлөгөө гарган хоёр сарын хугацаанд шуурхай хэрэгжүүлэн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг үүрэг болголоо. Түүнчлэн ХСҮТ-д хавдрын урьдчилан сэргийлэлт, тандалт судалгаа, эрт илрүүлэлт зэрэг нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг

эрчимтэй зохион байгуулах, олон улсад шинээр бүртгэгдэж буй хавдрын эмийг эмчилгээнд нэвтрүүлэх, хог хаягдлын менежментийг сайжруулах, хавдрын оношилгоо, эмчилгээний чиглэлээр бусад эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах чиглэл өгсөн юм.

Баталгаатай газарт мөнгөн дэвсгэрт солиулахыг анхаарууллаа

Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотойгоор ЦЕГ-аас иргэдэд мөнгөн дэвсгэрт солиулахдаа баталгаатай газар хандаж, сайтар шалгаж авахыг анхааруулж байна. Тодруулбал, БНХАУ-ыг зорих иргэдийн тоо эрс нэмэгдэж буй

энэ үед хуурамч мөнгөн дэвсгэрийн асуудал их гарч байгаа ажээ. Гадны орнуудад 1999, 2005 онд үйлдвэрлэгдсэн хуурамч 100, 50 юанийн дэвсгэрт ихээр тархсан байна. 2005 оны юаныг цаасан дээр үрэхэд будаг гардаг бол хуурамч

дэвсгэртээс гардаггүй. Мөн нүүрэн талын доорхи ногоон өнгөөр гялаалдаг 100 гэсэн тооны өнцгийг өөрчлөөд харахад бор саарал болж хувирдаг бол хуурамч дэвсгэртнийх өөрчлөгддөггүй аж.

Зам тээврийн ослын улмаас нэг хүн амиа алджээ

Улаанбаатар хотын Замын цагдаагийн газрын ЖШУХ-г өчигдөр буюу энэ сарын 15-нд зам тээврийн ослын 249 дуудлага бүртгэгдсэн бөгөөд нэг хүн амиа алдаж, 11 хүн хүнд хөнгөн гэмтжээ. Тодруулбал, СБД-ийн нутаг Дамбадаржаа руу салдаг уулзвараас зүүн тийш "Тэнүүн огоо" ХХК-ий хойд замд Т.Prius маркийн авто машины жолооч

Д оршин суух хаяг, нэр нь тодорхойгүй 25-30 насны эрэгтэйг дайрч амийг нь хохироосон байна. Мөн БЗД-ийн нутаг Энхтайваны өргөн чөлөө, Жуковын музейн хойд замд Д нь унадаг дугуй унаж хөдөлгөөнд оролцохдоо Т.Наггег маркийн Ө жолоочтой авто машинтай шүргэлцэж улмаар унадаг дугуй унаж явсан 21 настай эрэгтэй Д гэмтсэн аж.

Түүнчлэн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 49 зөрчил илэрчээ. Тиймээс Улаанбаатар хотын Замын цагдаагийн газраас замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байхыг санууллаа.

ЗАВСАРЛАГА



Олимпын тэнгэрт

ТӨРИЙН ДАЛБААГАА НАМИРАХЫГ
ДАХИАД ХАРАХ НЬ ДАМЖИГГҮЙ

Э.ТУУЛ

Бразилийн Рио-Де-Жанейро хотноо зуны олимпын XXXI наадамд дүрвэгсдийн багтай нийлээд 207 орны 11 мянга гаруй тамирчин спортын 28 төрөлд 306 багц медалийн төлөө өрсөлдөж байгаа билээ. Харин "Рио-2016" олимпын дэвжээнд монголчууд спортын есөн төрөлд 43 тамирчин буюу "Москва-1980" олимпын түүхийг давтаж, хамгийн олон тамирчин илгээгээд байгаа юм. Монголын тамирчид маань энэ удаа уламжлалт төрлүүдээс зөвхөн гимнастик, дугуйгаар эрхээ авч чадаагүй бөгөөд шинээр таеквондогийн спорт нь Монголын олимпын 11 дэх төрөл болон нэмэгдсэн. Олимпод оролцож буй 43 тамирчны 41 нь эрхээ биелүүлэн оролцож байгаагаараа онцлогтой. Мөн манай 43 тамирчны 27 нь анх удаагаа

олимпын наадамд өрсөлдөж байна. Одоогийн байдлаар жудо, буудлага, байт харваа, бокс, усанд сэлэлт, хүндийн өргөлт, марафон гүйлт зэрэг төрөлд өрсөлдөж, тамирчид маань чамгүй амжилт үзүүлээд байгаа билээ. Медалийн буухиа ч үргэлжилж, Риогийн тэнгэрт Монгол Улсын алтан соёмбот далбаа намирч байна. Тодруулбал, Монгол Улсын гавьяат тамирчин, Азийн аварга, Дэлхийн аваргын хүрэл медальт Доржсүрэнгийн Сумъяа хамгийн түрүүнд мөнгөн медалийг энгэртээ гялалзуулсан бол боксын төрлийн эрэгтэйчүүдийн 60 кг-ийн жинд мөнгөн медалийн төлөө манай тамирчин Д.Отгондалай Францын боксчин Софьян Умянтай тулалдсан ч шүүгч Францын боксчинд ялалтыг өгснөөр манай тамирчин "Рио 2016" олимпын наадмаас хүрэл

медаль хүртэж, медалийн буухиаг үргэлжлүүлсэн юм. Олимпын дэвжээнээс дахиад ч медаль хүртэх олон тамирчин монгол түмнийхээ итгэл найдварыг тээж буй. Тухайлбал, өнөөдөр Монголын чөлөөт бөхийн баг тамирчдын тэмцээн эхэлж байгаа. Манай 10 бөх Риогийн дэвжээнд хүч үзэхээс Пүрэвдоржийн Орхон, Очирбатын Насанбурмаа нар түрүүлж дэвжээнд гарна. Харин энэ сарын 18-нд 53 кг-д Э.Сумъяа, 63 кг-д С.Багцэнэг нар хүч үзэх бол чөлөөтийн эрэгтэйчүүд маань энэ сарын 19-ний өдрөөс барилдаанаа эхлүүлнэ. Энэ өдөр 57 кг-д Э.Бэхбаяр, 74 кг-д П.Өнөрбат нар барилдах бол 20-нд 86 кг-д О.Үйтүмэн, 125 кг-д Ж.Чулуунбат нар барилдана. Харин тэмцээний сүүлийн өдөр буюу наймдугаар сарын 21-нд 65 кг-д Г.Мандахнаран, 97 кг-д Д.Хүдэрбулга нар дэвжээнд

...Олимпын дэвжээнд хүч үзэж буй бүх баг тамирчиддаа амжилт хүсэхийн зэрэгцээ өнөөдөр Монгол Улсын төрийн дуулал эгшиглэж, Риогийн тэнгэрт алтан соёмбот далбаа минь дахин дахин мандах болтугай...

гарч барилдана. Үүнээс гадна "Рио-2016" олимпын наадамд Монгол Улсаас түүхэндээ анх удаа таеквондогийн төрлөөр ганцхан тамирчин оролцож байна

Тэр бол "Алдар" спорт хороо, үндэсний шигшээ багийн тамирчин П.Тэмүүжин юм. Тэрбээр "Рио 2016" олимпын наадамд таеквондогийн төрлийн 68 кг-ийн жинд эх орноо төлөөлөн төрөлдөө ганцаар хүч үзэх бөгөөд эхний тойрогтоо Мексикийн тамирчин Саул Гутьеррес Маседогтай учраа таарчээ. П.Тэмүүжин, Саул Гутьеррес Маседо нар энэ сарын 18-19-нд шилжих шөнийн 00:45 цагт тулалдана. Олимпын дэвжээнд хүч үзэж буй бүх баг тамирчиддаа амжилт хүсэхийн зэрэгцээ өнөөдөр Монгол Улсын төрийн дуулал эгшиглэж, Риогийн тэнгэрт алтан соёмбот далбаа минь дахин дахин мандах болтугай.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +20
Шөнө +10

Нөгөөдөр
Өдөр +19
Шөнө +9

Өдрийн зурхай

Аргын тооллын:
2016 оны 08-р сарын 17,
Лхагва гараг

Билгийн тооллын:
Шинийн 13 Дөрвөн ногоон
лэнгэтэй Цагаан торь өдөр

Наран ургах/шингэх:
05:51 / 20:02

Үс засуулбал:
Жаргал ирнэ.



Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, лусыг тахиж, тангарагаа буцаахад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэвтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал ирнэ.

ДУУЛГАХ СОНИН

Загвар өмсөгч
Э.Энхболд,
С.Сарнай нар
шинэ төрх
бүтээнэ

"Боловсрол" телевизийн уран бүтээлчид дэлхийн 39 оронд бүтээгдсэн "Яг түүн шиг" шоу нэвтрүүлгийг албан ёсны эрхийн дагуу эх орондоо амжилттай зохион байгуулсан билээ. Тус шоуны үзэгчдийн хайр хүндэтгэлийг хүлээсэн шилдэг оролцогчдын нэг бол яах аргагүй загвар өмсөгч Э.Энхболд, С.Сарнай нар. Тэд шоуны явцад өөрсдийгөө мэргэжлийн дуучнаас дутахааргүй авьяастай гэдгээ харуулаад амжсан. Тэгвэл авьяаслаг загвар өмсөгчид энэ удаад чадварлаг жүжигчид гэдгээ харуулж, "Өнгөт инээд" продакшны уран бүтээлчидтэй хамтарч кинонд дүр бүтээж байгаа аж. Одоогоор ямар кино гэдгийг нууцалж байгаа бөгөөд багийн бүрэлдэхүүнд жүжигчин С.Өлзийхүү, Х.Баярмаа, А.Алтанхуяг, "Шинэ үе"-ийн жүжигчин Отгоо, Х.Намуун нар багтжээ. Ямартай ч залуу загвар өмсөгчид шинэхэн уран бүтээлээрээ үзэгчидтэйгээ тун удахгүй уулзах нь.

TENGIS
МУГАЛГАА

Нэгэн залуу хайр дурлалынхаа төлөө өглөө бүр хийдэг дадал зуршил болсон гэнэтийнхээ бэлгийг хайртай охиндоо барьснаар киноны үйл явдал эхэлнэ. Үүнээс үүдэж өөр хайр дурлалтай учирна. Энэ хайр дурлалыг нь хоёр найз нь эсэргүүцэж киноны үйл явдлыг өрнүүлж асуудлыг улам хурцдуулна.



Засгийн газрын нууц агентлаг маш нууц ажиллагаа явуулахын тулд шоронд хоригдож байгаа онц ноцтой гэмт хэрэгтнүүдэд өршөөл үзүүлэхээр амлаж золиосны суман бүрдүүлнэ.

УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ



Гарас уулгацаа 2016.08.19



Гарас уулгацаа 2016.08.19



Гарас уулгацаа 2016.8.19



Гарас уулгацаа 2016.08.26



Гарас уулгацаа 2016.08.02